

“ШУДАРГА НИЙГМИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Нэг. Танилцуулга

Монголчууд танил талаараа асуудлыг шийдэх хандлагатай байдаг. Үүнийг хөндлөнгөөс харж байгаа хүүхэд залуучууд ч бас ийм төлөвшилттэй болж хүмүүждэг. Тиймээс Авлигатай тэмцэх газар, “Мерси кор олон улсын байгууллагатай хамтран “Шударга нийгмийн төлөө хамтдаа” аяныг зохион байгуулсан. Тус аян нь 2013 оны 9 дүгээр сарын 1-нээс 2013 оны 12 дугаар сарын 9-нийг хүртэл гурван сарын хугацаатай үргэлжилсэн бөгөөд хүүхэд залуусыг багаас нь төлөвшүүлж, ёс зүйн боловсрол олгож, авлигыг жигшиж, шударга ёсыг эрхэмлэх үзэлтэй болгох нөлөөллийн ажлуудыг хийсэн.

Хоёр: Сошиал медиа

Хүмүүсийн хандлага, зан төлвийг өөрчлөх зорилгоор сошиал маркетингийг ашигладаг туршлага дэлхий дахинд байдаг. Тус аяны хүрээнд бид сошиал медиа чиглэлээр хүүхэд залууст зориулсан Хамтдаа.мн вэб сайт, Хамтдаа.мн фэйсбүүк хуудас ажиллуулж эхэлсэн.

Хүүхэд, залуус болон иргэдэд зориулж Хамтдаа.мн вэб сайтад Онцлох мэдээ, Ухаалаг зөвлөгөө, ухаалаг хичээл, эх орон авлигын эсрэг зэрэг меню нээж өгсөн бөгөөд нийт 22 мэдээлэл оруулсан.

The screenshot shows the website interface for 'Авлигагүй нийгмийн төлөө' (www.XAMTDAА.mn). The header includes navigation links: ОНЦЛОХ, УХААЛАГ ЗӨВЛӨГӨӨ, УХААЛАГ ХИЧЭЭЛ, ЭХ ОРОН АВЛИГЫН ЭСРЭГ. The main content area features a large collage of images on the left and a list of news articles on the right. The articles include:

- “Шударга нийгмийн төлөө хамтдаа” аяны хүрээнд “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зарлаж байна. Оюутан оюунлаг залуус та бүхнийг идэвхтэй оролцохыг урьж байна
- “АВЛИГААС АНГИД НИЙГЭМ” ЗУРАГТ ХУУДАС БҮТЭЭХ УРАЛДААНЫГ ЗАРЛАЖ БАЙНА. Оюутан оюунлаг залуус та бүхнийг идэвхтэй оролцохыг урьж байна
- Аймгуудын албан ёсны цахим хуудасны ил тод байдал
- Хамтдаа төслийн хүрээнд нийслэлийн III дугаар амаржих газарт ажиллав
- Хүүхдийн шударга байдлын түвшинг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулла

News articles on the right:

- ХЭНТИЙ АЙМАГТ “ШИЛЭН ДАНС” НЭВТЭРЛЭЭ 2014/04/04
- “ТУНГАЛАГ ТӨСӨВ”-ИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ ХАНДЛАГАД ЭЭРЭГ ӨӨРЧЛӨЛТ ГАРЧ БАЙНА 2014/04/04
- “ХУУЛЬ ДҮРЭМ БОДИТ АМЬДРАЛД, ИЛ ТОД ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА” АЯН ХОВД АЙМАГТ АМЖИ ... 2014/03/14

At the bottom left, there is a banner for “АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ”.

Фэйсбүүк хэрэглэгчдийн дунд шударга ёсны талаар академик мэдээлэл өгөх зорилгоор Хамтдаа.мн фэйсбүүк хуудас нээж өгсөн. Фэйсбүүкт оруулсан мэдээлэл видеогоор 6, зурагт мэдээ 174 нийт 180 мэдээлэл оруулсан байна.

Хамтдаа.мн фэйсбүүк хуудас 2013 оны 12 дугаар сарын 2-ны өдөр нийт 634 хандагчтай ажиллаж байна. Цаашид 10 000 хандагчтай болох төлөвлөгөөтэй байна.



Гурав: Уралдаан, тэмцээн

1. “Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэхэд оюутан залуусын оролцоо” сэдэвт Нийслэлийн аварга шалгаруулах парламентын мэтгэлцээний тэмцээнийг 2013 оны 11 дүгээр сарын 5-15-ны өдөр хүртэл зохион байгуулсан. Парламентын мэтгэлцээний тэмцээнийн төгсгөлийн шалгаруулалт МУИС-ийн лекцийн дугуй зааланд болсон бөгөөд тэмцээнийг “National time news” телевиз бүтэн нэвтрүүлэг хийж 11 сарын 21-нд олон нийтийн хүртэл болгосон. Тус тэмцээнд нийт 6 их, дээд сургуулийн 96 баг оролцож, нийт 192 оюутан залуус оролцсон.



- “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам /Асуудал ба шийдэл/” сэдэвт онол арга зүйн бага хурлыг 2013 оны 12 дугаар сарын 1-ний өдөр МУИС-ийн Олон улсын харилцааны сургуулийн лекцийн танхимд амжилттай зохион байгуулсан байна. Тус онол арга зүйн бага хурлын зардлыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр санхүүжүүлсэн.



- Дизайн сонирхогч залууст зориулж “Авлигаас ангид нийгэм” зурагт хуудасны уралдааныг 2013 оны 11 дүгээр сарын 29-нөөс 12 дугаар сарын 07-ны өдрийг хүртэл зохион байгуулсан бөгөөд тус уралдаан ирүүлсэн бүтээлүүдийг Хамтдаа.мн фэйсбүүк хуудсанд тавьж олны хүртээл болгож цаашид зурагт хуудас болгон хэвлүүлж төрийн байгууллагуудаар тараана.

Дээрх тэмцээнүүдийн зарлалын постерийн эх бэлтгэлд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, постер хэвлүүж, МУИС-ийн салбар сургуулиуд, Отгонтэнгэр, Шихихутуг, ШУТИС, Удирдлагын академи, Монгол дээд сургууль, Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Соёмбо дээд сургууль зэрэг төрийн, хувийн өмчийн 20 гаруй их, дээд сургуулиудад зарлалыг тараасан. Тус тэмцээнүүдийн удирдамжийг боловсруулж, тэмцээнд оролцох оюутан залуусын бүртгэлийг явуулж, зохион байгуулах ажлын төсвийг боловсруулсан.

Дөрөв: Оюутан залууст зориулсан лекц /Шударга хүний долоон дадал/

Хүүхэд залуучуудад шударга ёсыг сурталчлан таниулж, өдөр тутмын амьдралдаа мөрдлөг болгон хэвшүүлэхэд түлхэц өгөх зорилготой “Шударга хүний долоон дадал” лекцийг ЕБС-ийн ахлах ангийн сурагчид болон их, дээд сургуулиудын 1 болон 2 дугаар курсийн ахлах ангийн оюутан залууст лектор багш Ү.Амарбат илтгэл тавьсан. Одоогийн байдлаар дараах сургуулиудад тус лекцийг зохион байгуулсан байна. Нийслэлийн Ерөнхий боловсролын 79, 65, 62, 42, 23, 1, 5, Орос 3, Хобби, МУИС-ын лицей Экологийн сургууль, Багахангай дүүргийн “Хангай”, Налайх “Голомт”, Багануур дүүргийн Цогцолбор сургууль, ШУТИС-ийн салбар сургуулиуд, Соёмбо дээд сургууль, Монгол дээд сургууль, Цагдаагийн сургууль, Хил хамгаалахын сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын сургууль, Онцгой байдлын сургууль, ахлагчийн сургууль, Удирдлагын сургууль, Шихихутуг хууль зүйн дээд сургууль, Татварын ерөнхий газар зэрэг нийт 4900 гаруй оюутан залуус сурагчид лекцэд хамруулсан байна. Тус лекцийг Азийн сан олон улсын байгууллага санхүүжүүлсэн.



Тав: Аяны дуу, клип

Шударга нийгмийн дуу хоолой болгох зорилготой амьд хөгжмийн “Компас” хамтлагтай хамтран “Хамтдаа” хэмээх нэртэй 3 минутын дууг бүтээсэн. Цаашид клипжүүлэх төлөвлөгөөтэй байгаа.



Зургаа: Хэвлэл, нийтлэл

1. МҮОНРТ-тэй хамтран 2013 оны 12 дугаар сарын 4-ний өдөр “Шударга нийгмийн төлөө хамтдаа” шууд нэвтрүүлгийн зохион байгуулалтыг хариуцаж ажилласан. Үүнд ерөнхий боловсролын сургуулийн 105 дугаар дунд сургуулийн 100 сурагчийг оролцуулж, “Компас” хамтлаг “Хамтдаа” дууг дуулж, лектор Ү.Амарбат “Шударга хүний долоон дадал” лекц тавьсан бөгөөд оюутан Н.Энхбадралт “Амьдрал биднийг өөрчлөхөөс өмнө бид амьдралыг өөрчилнө” сэдэвт илтгэлийг тавьж нэвтрүүлэгт орсон.

Долоо: Шударга нийгмийн төлөө хамтдаа “Парад” алхаа

Дэлхий нийтийн залуусын өдөр 12 дугаар сарын 7-нд “Шударга нийгмийн төлөө хамтдаа” парад алхаа хийсэн. Тус парад алхааг “Зориг сан” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан. Парад “Централ таур” төвийн урд талбайгаас МУИС-ийн хоёрдугаар байрны урд талбай дээр очиж “Хамтдаа” хэмээх үг бүтээж цааш Засгийн газрын 5 дугаар байранд очиж хаалтын арга хэмжээг үзэж сонирхсон.



Найм: Төслийн хүрээнд хамтран ажилласан байгууллагууд

1. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
2. НҮБ-ын Мансуурал бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба
3. Азийн сан ОУБ
4. Мерси Кор ОУБ
5. МУИСургууль
6. МУИСургуулийн оюутны холбоо
7. Батлан хамгаалах их сургууль
8. Хууль сахиулах их сургууль
9. Зориг сан
10. Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
11. Сэвэн телевиз ХХК
12. Хөх Монгол принтинг ХХК
13. National time news телевиз
14. МҮХАҮТ
15. Отгонтэнгэр их сургууль

2013 он